



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2016 оны сар өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэ тогтоолыг мөрдөж эхэлсэн өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 250 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГА

С. ДАВААСҮРЭН

ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь ердийн даатгалын компани (цаашид “даатгагч” гэх)-ийн даатгалын нөөц сан(цаашид “нөөц сан” гэх)-ийн хөрөнгөөрхийх хөрөнгө оруулалтын ангиллыг тодорхойлох, хэмжээ хязгаарыг тогтоох замаар даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, даатгагчийн мөнгөн хөрөнгийг хангалттай хүрэлцэхүйц, баталгаатай байлгахад оршино.

Хоёр. Хөрөнгө оруулалт хийхэд учирч болох эрсдэл

2.1.Даатгагч нөөц сангийн хөрөнгөөрхөрөнгө оруулалт хийхдээ учирч болох дараах үндсэн эрсдэлүүдийг тооцоолно:

2.1.1.Зах зээлийн эрсдэл. Зах зээлийн үнийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл. Үүнд хүүгийн түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл болон бусад үнийн эрсдэл хамаарна.

2.1.2.Авлагын эрсдэл. Үнэт цаас гаргагч, харилцагч түнш болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн байдал муудахүүнээс болж үнэт цаас хугацаандаа төлөгдөөгүйн улмаас даатгагч санхүүгийн хохирол амсах эрсдэлтэй. Энэ төрлийн эрсдэлд үнэт цаас төлөгдөхгүй байх, үнэт цаас гаргагчийнүнэлгээ буурах зэрэг эрсдэлүүд орно.

2.1.3.Хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл. Даатгуулагчдад их хэмжээний даатгалын нөхөн төлбөр олгох шаардлагатай тохиолдолд даатгагчийн хөрөнгийн хөрвөх чадвар хүрэлцэхгүйн улмаас бэлэн мөнгөний дутагдалд орох эрсдэлтэй. Ийм төрлийн эрсдэлд хөрвөх чадварын үнэлгээний эрсдэл, салбаруудад оруулсан хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл, хөрөнгийн сангийн эрсдэл зэрэг эрсдэлүүд орно.

2.2.Даатгагчид энэ журмын 2.1-д заасан эрсдэлүүдийг удирдахад дараах шаардлага тавигдана:

2.2.1.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөндөө эрсдэлийг удирдах бодлого, стратегийг тусгаж хэрэгжүүлэх;

2.2.2.Энэ журмын 2.2.1-д заасан бодлого, стратегийн дагуу хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай арга замыг оновчтой сонгож, шалгарсан менежментийг хэрэгжүүлэх;

2.2.3.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг үнэлэх, хянах, тайлагнахад тохиромжтой тогтолцоог бүрдүүлсэн байх /Тухайлбалхөрөнгө оруулалтын журам боловсруулах,дотоод хяналтын нэгжийн чиг үүрэгт оруулах гэх мэт/;

2.3.Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) энэ журмын 2.2-г заасан даатгагчийн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа, даатгагчийн хөрөнгө оруулалтын эрсдэлийн тооцоолол, эрсдэлийн үнэлгээний аргачлал, хяналтын болон тайлагналын горим зэрэгт хяналт тавина.

**Гурав. Холбогдох этгээд болон түүнтэй холбоотой этгээд буюу
хөрөнгө оруулалтын хязгаарлалт**

3.1.Нөөц сангийн хөрөнгөөр Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хязгаарлалтаас гадна дараах этгээдэд хөрөнгө оруулалт хийхийг хязгаарлах бөгөөд энэхүү этгээд нь нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхэд эрсдэл бүхий этгээдэд тооцогдоно:

3.1.1.Даатгалын тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан холбогдох этгээд;

3.1.2.Даатгагчийн болон холбогдох этгээдийн хувь нийлүүлэгч болон хувьцаа эзэмшигч;

3.1.3.Даатгалын компанийн хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, даатгалын салбарынзахирал, тэдгээрийн өвөг эцэг, эмэг эх, эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд;

3.1.4.Холбогдох этгээдтэй хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;

3.1.5.Даатгалын компани өөрөө холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

Дөрөв. Хөрөнгө оруулалт хийх, байршуулахад тавигдах шаардлага

4.1.Даатгагч нь нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөтэй байх бөгөөд уг төлөвлөгөө нь энэ журмын 5.1болон 5.2-т заасан шаардлагыг хангасан байна.

4.2.Даатгагч нь нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөгөө жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Хороонд ирүүлж байна.

4.3. Хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөг энэ журмын 5.1 болон 5.2-т заасан хэмжээ, хязгаарлалтын хүрээнд боловсруулсан байна;

4.4.Даатгагч нь нөөц сангийн хөрөнгөөр гадаад улсад хөрөнгө оруулалт хийхдээ энэ журмын 2 дугаар хавсралтад заасан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж буй энэ журмын 5.2-т заасан хөрөнгийн ангиллуудад хөрөнгө оруулж болох бөгөөд хөрөнгө оруулж буй тухайн үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл нь “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн ВВВ болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй байна.

4.5.Даатгагчийн гүйцэтгэх удирдлага нь зөвхөн даатгагчийн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлаар баталсан хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг явуулна.

4.6.ТУЗнь даатгалын холбогдох хууль, журмын биелэлт болон хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөний гүйцэтгэл, эрсдэлийн удирдлага, мэдээлэл, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл болон хөндлөнгийн аудитын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана.

4.7.Даатгагчийн нөөцийн сангийн нийт хөрөнгийн дүнгээс хөрөнгө оруулалтын дүнг хассан үлдэгдэл нь мөнгөн хөрөнгөөр байршина.

4.8. Энэ журмын 5.1, 5.2болон 4.7-дтус тус зааснаас бусад хэлбэрээр нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх, байршуулахыг хориглоно.

Тав. Хөрөнгө оруулалтхийх ангилал, хувь хэмжээ

5.1.Даатгагч нөөц сангийн хөрөнгөөр дотоодхөрөнгө оруулалт хийж, хөрөнгөө байршуулахдаа дараах ангилал, хэмжээ хязгаарт нийцүүлнэ:

Хөрөнгийн ангилал		Хөрөнгө оруулах дээд хувь
5.1.1.	Засгийн газрын бонд	100%
5.1.2.	Төв банкны үнэт цаас /Монгол банкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасыг ойлгоно/	100%

5.1	5.1.3.Банкны хадгаламж		100%
	5.1.4.Банкны хадгаламжийн сертификат		50%
	5.1.5.Санхүүгийн түрээс/Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 3.1, 3.2-т заасныг ойлгоно/		10%
	5.1.6.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас/Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасныг ойлгоно/		60%
	5.1.7.Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно/		20%
	5.1.8.Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл		60%
	5.1.9.Компанийн өрийн хэрэгсэл		20%
	5.1.10.МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	5.1.10.а I ангилал	10%
		5.1.10.б II ангилал	5%
	5.1.11.Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө		20%
Нөөц сангийн нийт хөрөнгөөс дотоодод хийх хөрөнгө оруулалтын дээд хэмжээ		100%	

5.2. Даатгагч нөөц сангийн хөрөнгөөр гадаад улсад хөрөнгө оруулалт хийж, хөрөнгөө байршуулахдаа дараах ангилал, хэмжээ хязгаарт нийцүүлнэ:

Хөрөнгийн ангилал		Хөрөнгөөруулах дээд хувь
5.2	5.2.1. Засгийн газрын бонд	2%
	5.2.2. Төв банкны үнэт цаас	2%
	5.2.3. Компанийн өрийн хэрэгсэл	1%
	Нөөц сангийн нийт хөрөнгөөс гадаадулсад хийх хөрөнгөөруулалтын дээд хэмжээ	5%

5.3. Даатгагч нөөц сангийн хөрөнгөөс хөрөнгө оруулах хэмжээг тооцохдоо нөөц сангийн хөрөнгийн дүнг харгалзах хөрөнгө оруулалт хийх хувиар үржүүлж тодорхойлно.

Зургаа. Хяналт тавих

6.1. Даатгагч нөөц сангийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтын тайлангаа энэ журмын 1 дүгээр хавсралтын “Маягт-1”, “Маягт-2”-оор тус тус гаргаж, улирал бүр санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлнэ.

6.2. Даатгагч гадаад улсад хөрөнгө оруулалт хийсэн бол тухайн үнэт цаас гаргагчийн нэр, үйл ажиллагааны чиглэл, бүртгэлтэй улс, олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ зэргийг тодорхой дурдаж, энэ журмын 6.1-д заасан тайлангийн хамт Хороонд ирүүлнэ.

6.3. Даатгагчийн нөөц сангийн хөрөнгөөр хийж буй хөрөнгө оруулалтад Хороо улирал бүр хяналт тавьж, холбогдох санал дүгнэлтийг даатгагчийн зайны хяналтын дүгнэлтэд тусгана.

6.4. Хороо энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Ердийн даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын 1 дүгээр хавсралт
“Маягт-1”

Ердийн даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгөөр дотоодод хөрөнгө оруулалт хийсэн тайлан

Хөрөнгийн ангилал		Даатгалын нөөц сангийн хөрөнгөөр оруулалт хийх дээд хувь	Хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөө /хувиар/	Хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөө /хувиар//	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /хувиар/
Баганын дүн		1	2	3	4	5
1	Засгийн газрын бонд	100%				
2	Төв банкны үнэт цаас	100%				
3	Банкны хадгаламж	100%				
4	Банкны хадгаламжийн сертификат	50%				
5	Санхүүгийн түрээс	10%				
6	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	60%				
7	Хөрөнгө оруулалтын сан	20%				
8	Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	60%				
9	Компанийн өрийн хэрэгсэл	20%				
10	МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	I ангилал	10%			
		II ангилал	5%			
11	Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	20%				
12	Нийт хөрөнгө оруулалтын дүн					

“Ердийн даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын 1 дүгээр хавсралт
“Маягт-2”

Ердийн даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгөөр гадаад улсад хөрөнгө оруулалт хийсэн тайлан

Хөрөнгийн ангилал		Нөөцийн сангийн хөрөнгөөр оруулалт хийх дээд хувь	Хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөө /хувиар/	Хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөө /хувиар//	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /хувиар/
Баганын дүн		1	2	3	4	5
1	Засгийн газрын бонд	2%				
2	Төв банкны үнэт цаас	2%				
3	Компанийн өрийн хэрэгсэл	1%				
5	Нийт хөрөнгө оруулалтын дүн	5%				

“Ердийн даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын 2 дугаар хавсралт

Ердийн даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгөөр
хөрөнгө оруулалт хийх Олон улсын хөрөнгийн
биржүүдийн жагсаалт

1. NASDAQ Stock Market
2. Tokyo Stock Exchange
3. London Stock Exchange
4. Shanghai Stock Exchange
5. Hong Kong Stock Exchange
6. Toronto Stock Exchange
7. Australian Securities Exchange
8. Korea Stock Exchange
9. Moscow Interbank Currency Exchange
10. New York Stock Exchange

--oo00oo—

